




**ТЭНГЭРЛИГ**

МЕДИА ГРУПП

# **ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП MSE: TNGR**

**ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**2023**



# АГУУЛГА



01. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА	02	02. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	
1.1 ТУЗ-ИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН	05	2.4 ОРИ СТУДИОС ХХК	27
1.2 УДИРДЛАГЫН БҮТЭЦ	07	2.5 МОНГОЛ ТЕЛЕВИЗ ХХК	33
1.3 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ	08	03. КОМПАНИЙН ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	43
02. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	10	04. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ТАЙЛАН	48
2.1 ПРО МЕДИА НЕТВОРК ХХК	12		
2.2 АНРИД ХХК	18		
2.3 МПЕРС ХХК	23		



01

**КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА**

# КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



ТэнГэрЛиг Медиа Групп (MSE: TNGR) нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна.


Группын бүрэлдэхүүнд одоогийн байдлаар

Охин компани: ТэнГэр ТВ, Анрид

Хараат компани: Монгол ТВ, ОриСтудиос, Мперс компаниуд хамаарагдаж буй.

Нээлттэй, хувьцаат медиа компани байснаараа олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөжөөс нь хүртэх боломжийг бүрдүүлж байгаа. Мөн цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, түүгээрээ дамжуулан нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах зорилготой юм.

# КОМПАНИЙН БҮТЭЦ



# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



## Ердийн гишүүд



**Г.Уянга**  
ТУЗ-ийн дарга  
Ард Пропертиз ХХК  
Гүйцэтгэх захирал



**Г.Бат-Эрдэнэ**  
Тэнгэрлиг Медиа  
Групп ХК Гүйцэтгэх  
захирал




**Ч.Батхүү**  
Брикланд ХХК  
Гүйцэтгэх захирал



**Б.Золбоо**  
Ард Санхүүгийн  
Нэгдэл ХК,  
Гүйцэтгэх захирал



**Н.Мөнхнасан**  
Монполимет  
групп  
ТУЗ-ийн дарга



**А.Ундрал**  
ТэнГэр Телевиз,  
Гүйцэтгэх захирал

## Хараат бус гишүүд



**В.Ганзориг**  
Bat Solution  
Partners  
УЗ-ийн дарга



**Н.Цогт**  
Бона лекс хуулийн  
товчоо, Гүйцэтгэх  
захирал



**Б.Наранзун**  
Лето Мьюзик ХХК,  
Гүйцэтгэх захирал

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ХОРОО



## Аудитын хороо



**В.Ганзориг**



**Ч.Батхүү**



**Б.Наранзун**

## Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо



**Б.Наранзун**



**Н.Цогт**



**Г.Уянга**

## Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо



**В.Ганзориг**



**Н.Мөнхнасан**



**А.Ундрал**



**Б.Золбоо**

# УДИРДЛАГЫН БАГ



ТЭНГЭРЛИГ МЕДИА  
ГРУПП

**TNGR:**  
Гүйцэтгэх захирал



**Г.Бат-Эрдэнэ**

**TNGR:** Санхүү эрхэлсэн  
захирал



**Д.Бат-Оюун**

ОХИН КОМПАНИЙН  
УДИРДЛАГА

**TenGer TV болон Unread:**  
Гүйцэтгэх захирал



**А.Ундрал**



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, %




2022/06/30

Нэгжийн  
хаалтын ханш **13,200₮**

Нийт хувьцаа **6,000,000**

Нийт үнэлгээ **79 т6**



2023/06/30

Нэгжийн  
хаалтын ханш **11,920₮**

Нийт хувьцаа **6,000,000**

Нийт үнэлгээ **71 т6**

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, %



№	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД	2021/12/31		2022/06/30		2023/06/30	
		Тоо	%	Тоо	%	Тоо	%
1	Гэр интерьер дизайн	2,225,097	37%	2,208,264	36.8%	2,196,580	36.6%
2	Ард Санхүүгийн Нэгдэл	1,393,099	23.2%	1,385,784	23%	1,358,262	22.6%
3	Л.Чинбат	692,175	11.5%	692,175	11.5%	692,175	11.5%
4	Г.Бат-Эрдэнэ	692,292	11.5%	692,292	11.5%	692,292	11.5%
5	Н.Мөнхнасан	600,000	10%	600,000	10%	600,000	10%
6	Их Бит	180,000	3%	180,000	3%	180,000	3%
7	Ардын тэтгэврийн данс ХХК	45,100	0.7%	45,039	0.7%	45,894	0.7%
8	И АЙ ТИ ХХК	45,000	0.7%	45,000	0.7%	34,856	0.5%
9	Ард менежмент ҮЦК ХХК	25,629	0.4%	25,501	0.4%	43,369	0.7%
10	Бусад	101,608	2%	125,945	2.4%	156,572	2.9%
НИЙТ		6,000,000	100%	6,000,000	100%	6,000,000	100%

The background is a dark blue gradient with a grid of small, light blue dots. In the top right corner, there is a small logo consisting of a triangle of dots in blue, purple, and orange. The large '02' logo is the central focus, with a vibrant gradient from blue at the top to orange at the bottom.

# 02

**КОМПАНИЙН ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**



**ТЭНГЭРЛИГ**

МЕДИА ГРУПП

**01**

2023 оны 02 сарын 07-ны эчнээ санал хураалтаар 2022 онд Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг гаргасан.

**02**

ТУЗ нь 2023 оны хагас жилийн хугацаанд нийт 1 удаа биечлэн хуралдаж, эчнээ хэлбэрээр 3 удаа санал хураасан

**03**

Хүлэгт хүннү Аудит ХХК-аар 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн

**04**

TNGR, охин болон хараат компаниуд санхүүгийн тайлан (НББОУС) 27-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн аудитын дүгнэлт авсан

**05**

2023/04/28-нд хувьцаа эзэмшигчдийн хурлыг 85.7%-ийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулсан


**06**

ХЭ-ийн хурлаар 3 асуудал хэлэлцсэн бөгөөд тус бүр 85%-с дээш зөвшөөрсөн санал авсан



**TEN** HD  
**GER**


# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ОНЦЛОХ



**100 сая төгрөгийн** шагналын сантай “Үндэсний Мэтгэлцээний Лиг” оюуны реалити шоуг санаачлан, анхны улирлыг амжилттай зохион байгуулав. Лигт 20 их сургуулийн **40 багийн 200 тамирчин** шинэ дүрэм, шинэ форматын хүрээнд өрсөлдлөө.



Шинжлэх ухааны хүрээллийн хамгийн том цугларалт “**SciCon 2023**”-ийг зохион байгуулж, **700 гаруй оролцогчийг нэгтгэв**. Уг арга хэмжээний онцлох илтгэлүүд, ярилцлагуудыг телевиз болон сошиал хуудсаар үзэгчдэд хүргэв.



Дата, тоон өгөгдөл ашиглан нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой “**Дата дуран дататон**”-ы эхний тэмцээнийг зохион байгууллаа. Нийт **70 багийн оролцсон тэмцээний шилдэг өгөгдлүүдийг “7:10” мэдээллийн хөтөлбөрт онцлов**.

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ШУУД




Ховд аймгийн хөрөнгө оруулалтын форумын шууд дамжуулалтыг хийж гүйцэтгэлээ. Мөн шинэ санааны хакатон, залуучуудын зэрэг дагалдах эвентийг зохион байгуулав.



Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалтын шууд дамжуулалт, социал медиа идэвхжүүлэлтийг бүрэн хариуцан ажиллалаа. Олон улсын арга хэмжээг бие даан хариуцан ажиллав.



Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтын форум “UB Forum”-ийн брэндинг, медиа, шууд дамжуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Арга хэмжээний концепц, ложистик, формат болон брэндийг иж бүрнээр хариуцав.



Gen Z үеийн залуусын хамгийн том цугларалт “Update 2023” арга хэмжээг шууд дамжууллаа. Гадаа талбайгаас анх удаа дамжуулалт амжилттай хийв.


# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН КОНТЕНТ



Францын ерөнхийлөгч **Э.Макроны** Монгол улсад хийсэн айлчлалыг бүрэн эхээр шууд дамжуулж, тусгай сурвалжилга болон багц мэдээлэл бүхий тусгай хөтөлбөрийг хүргэлээ.



Хөгжлийн Банкны 2 сар гаруй үргэлжилсэн шүүх хурлыг өдөр бүр сурвалжилж, нийт 12 цуврал "Хөгжлийн банкны хөшигний ард" нэвтрүүлгийг хүргэв.






Монгол улсын ерөнхий сайдын нэрэмжит "Шинэ мянган" тэтгэлгийн албан ёсны медиа хамтрагчаар ажиллаж, вебсайт, цуврал эвент, социал идэвхжүүлэлт, видео контент бүтээлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.



"Тэрбум Мод" сангаас зарласан тогтвортой хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх шилдэг төслийн уралдаанд "Цэнхэр толбо" байгаль орчны мэдээллийн хөтөлбөр бүтээх төслөөр шалгарч, грант хүртлээ.



# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ИДЭВХЖҮҮЛЭЛТ



Мэргэжлийн онцлог, ач холбогдлын талаар танин мэдүүлэх зорилготой “Цагийн ажилтан” контентийн медиа салбарыг онцолсон дугаарт оролцож, редакцын нэг өдрийн ажлыг олон нийтэд сурталчлав.

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулан Eguur.mn сайтаас нийтэлдэг онцлох редакцаар нэрлэгдэж, цахим орчинд мэдээлэл хүргэлээ.



МИАТ-ын албан ёсны сэтгүүл “Mongolica”-ийн зуны дугаарт “Creative Nation” буланд сонгогдож, телевизийн алсын хараа, онцлох контентуудын талаар 4 нүүр нийтлэлд оролцлоо.

Дата дуран контент болон хакатоныг нээлттэй тоон өгөгдлийн ач холбогдлыг нийтэд түгээж буй сайн туршлага хэмээн Open News-ээс онцолж Англи хэл дээр нийтлэл гаргалаа.

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Үзүүлэлт	2022 Q2	2023 Q2	Жилийн өөрчлөлт
Нийт ажиллагсад	81	70	↓ -11
Хувьцаа эзэмшигч	2	2	0
Нийт зохион байгуулсан эвент	0	6	↑ +6
Нийт ажилласан шууд дамжуулалт, арга хэмжээ	4	14	↑ +10
Нийт мэдээллийн хөтөлбөрийн тоо	5	10	↑ +5
Нийт социал хандалтын тоо	3.5 сая+	15 сая+	↑ 4x





 **UNREAD™**

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



**300+**

Ажилласан  
нийтлэлийн тоо

**2.5m+**

Social media reach

**50+**

Хамтарсан  
байгууллагуудын тоо

**10+**

Урт хугацааны  
хамтрагчид

**10**

Зохион байгуулсан  
эвентийн тоо

**2800+**

Эвентэд ирсэн  
оролцогчдын тоо

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



## Unplug Khovd



- Орон нутагт анх удаа
- **300+** оролцогч
- **15+** илтгэгч
- **9** сэдэв
- **10+** сайн дурын ажилтан

## Unplug Khan bank



- Байгууллагад анх удаа
- **300+** оролцогч
- **10+** илтгэгч
- **7** сэдэв
- **50+** зочин

## DevSummit



- **2** өдөр
- **3** байршил
- **900+** оролцогч
- **20+** хамтрагч тал
- **50+** илтгэгч
- **40+** сайн дурын ажилтан

## Бусад/Хамтарсан




1. **Premium Group:** Төгс бүтээгч арга хэмжээ
2. **Сангийн яам:** Нээлттэй төсөв төслийн хаалтын арга хэмжээ
3. **Дэлхийн банк:** Төсвийн ил тод байдал эрдэм шинжилгээний хурал

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




## Тусгай контент



1. “Улаанбаатарын таатай оффис 2023” контентоо бэлтгэн цацав
2. “Бэлгийн хөтөч” контентуудаа цацав

## Шинэ контент



1. Unguide
2. Unread Art
3. Сарын онцлох стартапууд контентуудыг шинээр эхлүүлэн тогтмолжуулав

## Дотоод үйл ажиллагаа






1. 3 дахь удаагийн Growth хөтөлбөрөө 70 гаруй оролцогчтой эхлүүлэв
2. Шинэ ерөнхий редактор томилогдов
3. Journalism AI, Oxford Climate Journalism Network-д шалгарав

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




Үзүүлэлт	2022 Q2	2023 Q2	Жилийн өөрчлөлт
Нийт ажиллагсад	14	15	↑ +1
Хувьцаа эзэмшигч	3	2	↓ -1
Нийт зохион байгуулсан эвент	8	10	↑ +2
Нийт харилцагч байгууллагууд	45	55	↑ +10
Нийт контент	247	280	↑ +33
Нийт социал хандалтын тоо	1.9 сая	2.5 сая	↑ +0.6 сая







# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



- Хөрөнгө оруулагч үндэстэн чуулганд анх удаа
- 600+ оролцогч
- 1,000 тасалбар зарагдав



- Бид илүү байж чадна аяны хүрээнд Нийслэлийн Ерөнхий боловсролын 119, 29-р дунд сургуулийн нийт сурагчдад
- Хүүхдийн хадгаламж
- Ард Санхүү Нэгдлийн хувьцаа эзэмшүүлэв



- ICT EXPO 2023 анх удаа
- 300+ оролцогч
- 450 тасалбар зарагдав



# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



App  
642lotto.mn

Давуу тал, боломж:

- Илүү хялбар
- Түргэн шуурхай
- Илүү ойлгомжтой
- Монголын нэгдсэн лоттон платформ болох боломжтой



Гүйцэтгэл






**ORISTUDIOS**

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




**01** Oristudios.mn вэбсайтын ажлыг эхлүүлэв. Talent Management цэс дээрх уран бүтээлчдийн зураг авалтын ажил болон профайл мэдээллүүдийг бэлтгэв. Вэбсайт ажлын гүйцэтгэл-55%



**02** Хятадад барилгын студийн ажлтай холбогдолтой уулзалт, хэлэлцээрүүд хийв. Төслөө томоохон ЭСЯ-уудад танилцуулан, хамтын ажиллагааны талаар хэлэлцэв



**03** Ори Студиосын рэбрендинг-ийн ажлыг хийж гүйцэтгэв. Тэнгэрлиг медиа группийн жилийн тайлан-г бэлтгэв



# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



**04** Жил бүр уламжлал болгон ордодог “Хөрөнгө оруулагч үндэстэн” форумд оролцож Ори Бонд эзэмшигчдэд үйл ажиллагааны мэдээлэл хүргэв.



**05** Каннын кино наадам-д анх удаа оролцож, гадаад харилцаагаа өргөжүүлэн, ОУ-ын кино экспертүүдтэй туршлага солилцов



**06** Солонгосын кино урлагийн зөвлөлийн даргыг хүлээн авч уулзалт хийн, хамтын ажиллагааны талаар хэлэлцэв



# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН БАРИЛГА




**01** **Металл хийцийн тээвэрлэлт. Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллагыг сонгох ажил хийгдэж барилгын угсралт эхлэх бэлтгэл ажлууд хийгдсэн**



**02** **Металл хийц угсралтын ажил эхэлсэн үлдэгдэл материалын татан авалт хийгдсэн**



**03** **Металл хийцийн угсралтын ажил 40% болон сендвич хана, дээврийн материал худалдан авалтын гэрээ хийгдсэн**



# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН БАРИЛГА



**04** **Металл хийцийн**  
угсралтын ажил **70%**  
Хана дээврийн  
материал тээвэрлэлт,  
галаас хамгаалах  
будаг тээвэрлэлт  
хийгдсэн



**05** **Металл хийцийн** угсралт  
дуусч, Хана дээврийн  
угсралтын ажил хийгдэж  
эхэлсэн. Дэд бүцтийн ажил  
буюу дотор, гадна цахилгаан,  
ЦБУ, халаалт агаар  
сэлгэлтийн гүйцэтгэгч  
байгууллагуудтай гэрээ  
хийсэн



May 15, 2023 1:37:08 PM  
Урлах Нэгэн Эвэл  
Mongolia

**06** **Хана дээврийн**  
угсралтын ажил **90%**  
металл хийцийг галаас  
хамгаалах будгийн  
ажил дууссан, дотор  
сувагчлал болон дэд  
бүцтийн ажлууд  
эхэлсэн







# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




Үзүүлэлт	2022 Q2	2023 Q2	Жилийн өөрчлөлт
Нийт ажиллагсад	6	12	↑ +6
Хувьцаа эзэмшигч	2	2	0
Харилцагч байгууллагууд	5	11	↑ +6
Барилгын явц	10%	70%	↑ +60%
Хүлээж авсан гадны зочид төлөөлөгчид, хөрөнгө оруулагчид	10	10	0
Гадаад харилцагчид	10	20	↑ 10






**МОНГОЛTV**

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



7 хоног бүр эмч нар, интернэтээр зэвсэглэсэн энгийн хүмүүстэй өрсөлдөн бодит өвчтөн оношлох "Эмчийн эсрэг Интернэт" цэнгээнт, эрүүл мэндийн нэвтрүүлгийн **3-р улирлыг** амжилттай хийж үзэгчдийн хүртээл болгоод байна



Гэр бүлийн хамгийн үзүүштэй, олон мянган үзэгчдийн хүртээл болсон "Ардын буйдан" нэвтрүүлгийн **15/3-р улирлыг** амжилттай үзэгчдийн хүртээл болгосон



Мөн үзэгчдийн дунд үргэлж хүлээлт үүсгэдэг "Чимгээ" шоу нэвтрүүлгийн **5-р улирлыг** дахин зохион байгуулж, олон үзэгчдийн сэтгэлийг хөдөлгөж, баярлуулсан шоу нэвтрүүлгээ нийт үзэгчдэд амжилттай хүргэлээ



Бизнесийн номер 1 шоу нэвтрүүлгийн **2 дахь улирлыг** эхлүүлэн Монгол улсад амжилттай дахин нутагшуулж олны хүртээл болголоо

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Дэлхийн бизнесийн нэвтрүүлэг болох “Шарк танк Монгол” бизнесийн реалити нэвтрүүлгийг албан ёсны эрхтэйгээр **4 дэх удаагаа** олон мянган үзэгчдийн шилдэг шоу нэвтрүүлэг болгон ажиллалаа

Шинэчилгээ нэвтрүүлгийн **19 дугаарыг** үзэгч олны хүртээл болгон ажиллалаа



Нийгмийн мэдээлэлд ойрхон, үйл явдал онцлох сэдэв шинэлэг бүхний анхдагч эх сурвалжаар дамжуулан ажлын өдрүүдэд шууд явагдах шинэ төслийг эхлүүллээ

NBC Universal-н бүтээл **SUITS** олон ангит киноны Монгол хувилбарыг албан ёсны эрхтэйгээр бүтээж байна

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




Үзүүлэлт	2022 Q2	2023 Q2	Жилийн өөрчлөлт
Нийт ажиллагсад	144	149	↑ +5
Хувьцаа эзэмшигч	2	2	-
Нийт харилцагч байгууллагууд	142	181	↑ +31
Нийт зохион байгуулсан эвент	3	2	↓ -1
Нийт бүтээсэн шоу	14	12	↓ -2
Нийт бүтээсэн реклам	3	1	↓ -2



Монгол ТВ нь 2023 оны эхний хагас жилд Нийт 191 197 минутын шууд болон серверийн шинэ, шинэлэг нэвтрүүлэг, контентуудыг бэлтгэн хүргэсэн. Үүнээс 68 993 минут буюу 36% шинэ, 122 204 минут 64% хуучин буюу давталтыг нэвтрүүлэг эфирт нэвтрүүлсэн байна

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /Санхүү/



Ори Студиос төслийг санхүүжүүлэх зорилгоор Монгол Телевиз ХХК 12 сарын хугацаатай, **5.0 тэрбум төгрөгийн** бондын санхүүжилтийг **2023 оны 1-р улиралд амжилттай татав.**

Тус бондын санхүүжилт нь дахин сунгагдах нөхцөлтэй бөгөөд **2025 оны 1-р улиралд бүрэн төлөгдөнө.**

**2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийгдэж НББОУС дагуу бүртгэсэн болохыг баталгаажуулж зөрчилгүй хэмээх дүгнэлт авсан.**



# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



## Онцгой 7 хоног

Үзэгч болон Контент бүтээгчдэд “ОНЦГОЙ 7 ХОНОГ” цоо шинэ бүтээгдэхүүнийг санал болгож амжилттай зах зээлд нэвтрүүлэв. /23 киног нээж 50% нь өрсөлдөгч нарын үзэлтийг давав/

Үзэгч нарт - Онцгой үнээр түрүүлж үзэх боломж  
Контент бүтээгчдэд - Контент маркетинг

ҮР ДҮН: Тухайн нэг кино контент дээр борлуулалтаар өрсөлдөгч нараасаа илүү гарч чадсан.



# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



TVOD буюу контент түрээслэх үйлчилгээг амжилттай нэвтрүүлэв

Контентын сонголт муу байсан бол богино хугацаанд **300+** контент нэмж төрөл жанар баялаг болж цоо шинэ кино контент үзэгч нартаа санал болгож хэрэглээг нэмэгдүүлэв.

Original Content байхгүй үед хэрэглэгчийн тоо буурч, борлуулалт дагаад буурдаг үед нэвтрүүлж чадсанаар борлуулалтын орлого буураагүй.

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ONDO хамтран Bundle бүтээгдэхүүн гаргаж, эхний сард **1000 хэрэглэгч** авав



ТВ сувгуудыг **24 цагаар** ухраах, **нөхөж үзэх мөн видеог +10 -10 sec -ээр** үздэг болов



Судалгаа хийж үйлчилгээнийхээ **багцыг амжилттай өөрчлөв.** Хэрэглэгч нараас гомдол ирээгүй

Дундын дамжуулагчгүйгээр гадаадын контент бүтээгч нараас контентыг авч туршив.

# 2023 ОН Q2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



## 01

Контент бүтээгчидтэй гэрээ хийж ажилласан тоо **4-5 дахин** нэмэгдэв

## 03

Контент маркетингийг өрсөлдөгч нараас ялгаатайгаар мөн түрүүлж хийдэг болсон. Ингэснээр:



**Facebook reach 1000%**  
Өсөв (41,207,118)

## 02

Үзэгч нартай харилцах сувгийг хөгжүүлж асуудал гомдлын тоо **30%** буурав

## 04

FB дагагч **76,5%**-аар өсөв. Instagram **32.8%**-аар өсөв, мессежээр хандаж орж ирсэн хэрэглэгч **255,5%**-аар өсөв

**ДҮГНЭЛТ:** SVOD Хэрэглэгчийн тоо, үзэлт буурсан хэдий ч зөв үед TVOD-ыг нэвтрүүлж, мөн үйлчилгээний үнийг өөрчилж борлуулалтыг тогтоож нэмэгдүүлэв. Дараагийн зорилго буюу Original Content дээр ажиллах, ТВ BOX-той болох ажлын сууриа бэлдэж чадлаа гэж үзэж байна.



03

**КОМПАНИЙН ХАГАС ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН	2022 Q2	2022	2023 Q2	YOY	YTD
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4	5	1	(75%)	(80%)
Дансны авлага	1,364	13	15	(98.9%)	15.4%
Татвар, НДШ авлага	1	1	2	100%	100%
Бусад авлага	1,130	1,172	1,407	24.5%	20.1%
УТЗ	32	-	-	(100%)	-
Үндсэн хөрөнгө	8	6	3	(62.5%)	(50%)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	13,886	13,433	13,433	(3.3%)	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,216	3,704	2,883	137.1%	(22.2%)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,641</b>	<b>18,334</b>	<b>17,744</b>	<b>0.6%</b>	<b>(3.2%)</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>753</b>	<b>2,022</b>	<b>478</b>	<b>(36.5%)</b>	<b>(76.4%)</b>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>3,503</b>	<b>2,828</b>	<b>2,919</b>	<b>(16.7%)</b>	<b>3.2%</b>
Өмч-Хувьцаат	599	599	599	0%	-
Нэмж төлөгдсөн капитал	12,352	12,352	13,918	12.7%	12.7%
Эздийн өмчийн бусад хэсэг	309	857	250	(19,1%)	(70.8%)
Хуримтлагдсан ашиг	125	(324)	(420)	436%	29.6%
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН</b>	<b>17,641</b>	<b>18,334</b>	<b>17,744</b>	<b>0.6%</b>	<b>(3.2%)</b>



ОРЛОГЫН ТАЙЛАН	2022 Q2	2022	2023 Q2	YOY	YTD
<b>ОРЛОГО</b>					
Борлуулалтын орлого	0	44	13	0	(70.5%)
Хүүний орлого	70	0	0	(100%)	-
<b>ЗАРДАЛ</b>					
Борлуулалт, маркетингийн зардал	15	28	0	(100%)	(100%)
Ерөнхий ба удирдлагын зардал	201	561	118	(41.3%)	(79%)
Санхүүгийн зардал	139	315	45	(67.6%)	(85.7%)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз	0	125	(133)	-	(206.4%)
Бусад ашиг/Алдагдал	0	0	18	-	-
<b>ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)</b>	<b>(285)</b>	<b>(735)</b>	<b>(265)</b>	<b>(7%)</b>	<b>(63.9%)</b>
<b>ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)</b>	<b>(2,585)</b>	<b>(735)</b>	<b>(265)</b>	<b>(7%)</b>	<b>(63.9%)</b>




МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	2022 Q2	2022	2023 Q2	YOY	YTD
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(257)	(301)	(2)	(100.8%)	(100.7%)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(1,059)	(1,099)	(2)	(100.2%)	(100.2%)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	99	184	-	(100%)	(100%)
Зээлээс хүлээн авсан мөнгө	100	186	-	(100%)	(100%)
Зээлд төлсөн мөнгө	1	2	-	(100%)	(100%)
Цэвэр мөнгөн гүйлгээ	1,217	(1,216)	(4)	(100.3%)	(100.3%)
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	1,221	1,221	5	(99.6%)	(99.6%)
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4	5	1	(75%)	(80%)


# САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД TNGR сая.төг




ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ сая.төг




НИЙТ ХӨРӨНГӨ сая.төг




НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ сая.төг




НИЙТ ӨР ТӨЛБӨР сая.төг



ХУРИМТЛАГДСАН АШИГ сая.төг



ХУВЬЦААНЫ ХАНШ мян.төг







04

**КОМПАНИЙН ЗАСАГЛАЛТАЙ  
ХОЛБООТОЙ ТАЙЛАН**



## АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

2022.06

2023.06

Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.

2021 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд хөндлөнгийн аудитор оролцоогүй, дараагийн жилүүдээс хөндлөнгийн аудиторыг хуралд оролцуулж байх болно.

2022 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд “Хүлэгт хүннү аудит” ХХК-ийн Гүйцэтгэх захирал И. Гүррагчаа оролцож ХЭ-дэд мэдээлэл өгсөн.

Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.

Дотоод аудитын журмыг хэлэлцэн баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх болно.

ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар тус журмыг баталсан.

# ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН ӨӨРЧЛӨЛТ



## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2022.06

2023.06

ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.

Ээлжит ТУЗ-ийн хурлаар хорооны даргаар хараат бус гишүүнийг томилох болно.

ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 17-ны өдрийн 23/04 тоот тогтоолоор хараат бус гишүүн В.Ганзоригийг хороон даргаар томилсон.

Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.

Ээлжит ТУЗ-ийн хурлаар комплайнсын хяналтын журмыг хэлэлцэн батлах болно.

ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталсан.

# ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН ӨӨРЧЛӨЛТ



## ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

2022.06

2023.06

ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.

Ашигт ажиллагаанд хүрэх үед ХЭ-ийн ээлжит/ээлжит бус хурлаар цалин урамшуулал, олгох хэлбэр, давтамжийг хэлэлцэж батлах болно.

2023 оны 4 сарын 28-ны өдрийн ХЭ-ийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг хэлэлцэж баталсан.

Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.

Ээлжит ТУЗ-ийн хурлаар цалин урамшууллын журамд эдгээр зүйл шалгууруудыг нэмж тусган батлах болно.

ТУЗ-ийн 2023 оны 5 сарын 1- ний өдрийн 23/06 тоот тогтоолын гуравдугаар хавсралтаар Цалин урамшууллын бодлогыг баталсан.



## ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

2022.06

2023.06

Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.

Ээлжит ТУЗ-ийн хурлаар бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичгийг хэлэлцэн батлах болно.

ТУЗ-ийн 2023 оны 5 сарын 1-ний өдрийн 23/06 тоот тогтоолын тавдугаар хавсралтаар оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг баталсан.

Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.

2021 оны жилийн үйл ажиллагааны тайланд энэ талаар тусгаж өгөөгүй, 2022 онд үйл ажиллагааны тайландаа тусгаж өгөх болно.

Оролцогч талуудтай хамтран ажиллах бодлогыг 2023 онд баталсан бөгөөд 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд тус мэдээллийг тусгаж ажиллах болно.

# ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН ӨӨРЧЛӨЛТ



## КОМПАНИЙН СОЁЛ

2022.06

2023.06

Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.

Уг журманд мэдээлэл өгсөн этгээд буюу “шүгэл үлээгч”-ийн нууцлалыг хадгалах, түүний нэр хүнд, цалин урамшуулал, ажлын байрыг нь хамгаалах зохицуулалтыг ээлжит ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн нэмж тусгах болно.

ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар ТУЗ-ийн ёс зүйн кодексийн журамд нэмж оруулан баталсан.

Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.

Ээлжит ТУЗ-ийн хурлаар ёс зүйн дүрэмд эдгээр зүйл заалтуудыг нэмж тусган батлах болно.

ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар нэмж баталсан.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

2022.06

2023.06

Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.

Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг боловсруулан ээлжит ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн батална.

ТУЗ-ийн 2023 оны 5 сарын 1-ний өдрийн 23/06 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан.



**ТЭНГЭРЛИГ**

МЕДИА ГРУПП

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

